

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ШИНЭЭР БҮРТГҮҮЛЭХ БОЛОН НУУЦ ҮГ АВАХ



Шинээр байгуулагдсан Аж ахуйн нэгж, байгууллага E-Balance-д нэвтрэх эрх, нууц үг авахад Аж ахуйн нэгж, байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч Бүртгэлийн мэргэжилтэнд бүртгүүлэх хүсэлтэй албан бичиг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар болон эх хувийн хамт үзүүлэн авна.



Нэвтрэх болон нууц үг мартсан, сэргээн авах тохиолдолд Санхүү, Төрийн сангийн хэлтэст гаргасан албан хүсэлт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг өгч авна.

Нэвтрэх хэсэг





☐ Нууц үгээ мартсан уу?

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА ТАЙЛАН ШИВЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

ААНБ нь хагас, бүтэн жилийн Санхүүгийн тайланг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын дагуу

эхний хагас жилийн
санхүүгийн тайланг
07 дугаар
сарын 20-ны
өдрийн дотор

жилийн санхүүгийн
тайланг дараа оны
2 дугаар сарын
10-ны өдрийн дотор

Нэгтгэсэн болон
салбарын нэгдсэн
тайланг дараа оны
3 дугаар сарын
1-ний өдрийн дотор

цахим хэлбэрээр хүргүүлнэ.

<http://e-balance.mof.gov.mn>




Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр тайлагнахдаа мянгалчлан /мян.төг/, үнэн зөв, бүрэн шивсний дараа заавал илгээсэн байх шаардлагатай.



“Аудитын тухай хууль” /2015 он/-ийн 10.1 дэхь заалт, “Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журам” Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалын дагуу нийт хөрөнгийн хэмжээ 0,5 тэрбум төгрөгөөс дээш, борлуулалтын орлого 1,5 тэрбум төгрөгөөс дээш том ААНБ-ууд, ББСБ, ХЗХ, МҮЦБ, Сан,

- Гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ууд, Газрын тосны салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ууд жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар заавал баталгаажуулна. /Дээрх байгууллагууд нь E-Balance программын “Санхүүгийн тайлангийн тодруулга” хэсэгт аудит хийлгэсэн болон хийлгэх аудитын байгууллагын нэрийг давхар заавал сонгож илгээнэ/
- “Аудитын тухай хууль” /2015 он/-ийн 10.2.4 дэхь заалтын дагуу дээрх аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн жилийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 04 дүгээр сарын 30-ны дотор заавал Аудитын байгууллагатай гэрээ хийж, E-Balance системийн “Санхүүгийн тайлангийн тодруулга” хэсэгт тухайн гэрээ хийсэн аудитын байгууллагаа сонгож бөглөсөн байх. Хэрэв аудитын байгууллага буруу сонгосон тохиолдолд тайлан баталгаажихгүй болно.

- Тэмдэгтийн тайлбар:



- Илгээсэн санхүүгийн тайлангаа **БАТАЛГААЖИХ** хүртэл хяналт тавина. /Харилцагч санхүүгийн байгууллага нь илгээсэн санхүүгийн тайланг ажлын 15 өдрийн дотор хянаж баталгаажуулна/
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг E-Balance-ийн “Санхүүгийн тайлангийн тодруулга” хэсгийг заавал бүрэн гүйцэд бөглөсөн байх.

**Е-Balance
системд
баталгаажсан
тайланд
залруулга
хийх:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан үндэслэлээр аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайландаа залруулга хийлгэх бол залруулга хийлгэх хүсэлт, залруулга хийлгэх болсон шалтгаан, түүнийг тусгасан баримт, аудитын дүнэлт, тайланг хэвлэмэл байдлаар биечлэн тушаана.

Тайлангийн залруулгыг ажлын 5 хоногт багтаан залруулна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн залруулгыг аудитын дүгнэлтээр дараа оны 12 дугаар сарын 20-ний хүртэл залруулга хийнэ.

Албан бичиг /Дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс-д/
Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр /тогтоол/

Шийдвэр /тогтоол/-т дүрмийн сан нэмэгдүүлсэн тухай, хувьцаа эзэмшигчид, гишүүд, эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байна.

Завсрын санхүүгийн тайлан-2 хувь /цаасан хэлбэрээр биечлэн тушаана/

**Дүрмийн
санд
өөрчлөлт
орж
байгаа
тохиолдолд:**

Татан буугдаж байгаа тохиолдолд:

Албан бичиг /Дүүргийн Санхүү,
төрийн сангийн хэлтэс-д/

Татан буулгах тухай эрх бүхий
байгууллагын шийдвэр /тогтоол/
Шийдвэр /тогтоол/-т ямар шалтгаанаар
татан буугдаж байгаа, татан буулгах
комиссыг байгуулсан тухай тусгаж,
хувьцаа эзэмшигчид, гишүүд, эрх
бүхий этгээдүүд гарын үсэг зурж,
тамга, тэмдэг дарсан байна.

Татварын улсын байцаагчийн
акт, хасалтын карт

Санхүүгийн тайлан аудит хийлгэх

Хаалтын санхүүгийн тайлан-2 хувь
/цаасан хэлбэрээр биечлэн тушаана/

ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 11.18 зүйлийн 1.25 дахь заалт Ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргээ биелүүлээгүй; хүнийг 400 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 400,000 /Дөрвөн зуун мянга/ төгрөгөөр, хуулийн этгээдийг 4000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 4,000,000 /Дөрвөн сая/ төгрөгөөр торгоно.